



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 01299

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн Засаг даргын
Тамгын газрын Конторын хоёрдугаар барилгын
нэгдүгээр давхрыг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 74 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/729 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын Улсын байцаагчийн 2012 оны 02-07-92/1276, 2017 оны 07/103/99 дүгээр, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн 2019 оны 02-07-119/1887 дугаар дүгнэлтүүдийн дагуу тус дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй нийт 86,474,406 /наян зургаан сая дөрвөн зуун далан дөрвөн мянга дөрвөн зуун зургаан/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад дурдсан Конторын хоёрдугаар барилгын нэгдүгээр давхрыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар /Д.Дэлгэрмаа/-т зөвшөөрсүгэй.


2. Данснаас хасагдаж буй хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулахаар үнэлсэн 610,500 /Зургаан зуун арван мянга таван зуун/ төгрөгөөр худалдан борлуулж, орлогыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Нийслэлийн Төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлж, акт болон бусад бичиг баримтын бүрдэлд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т даалгасугай.

3. Өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар /Д.Дэлгэрмаа/-т даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Рэнцэнбямбад үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



115050000747

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны 16 дугаар сарын 29 -ны өдрийн 162/2020 дугаар тушаалын хавсралт



АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

№	Байгууллага	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл /2019.12.31/	Үлдэгдэл өртөг /2019.12.31/	Акталж, данснаас хасах үндэслэл
1.	Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар	Конторын хоёрдугаар барилга	1954	86,474,406.00	10,809,300.72	75,665,105.43	- Мэргэжлийн хяналтын Улсын байцаагчийн 2012.07.25-ны өдрийн 02-07-92/1276; - Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын Улсын ахлах байцаагчийн 2017.04.11-ний өдрийн 07/103/99; - Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн 2019.12.16-ны өдрийн 02-07-119/1887 дугаар дүгнэлтүүд
НИЙТ ДҮН				86,474,406.00	10,809,300.72	75,665,105.43	